



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 7/667

Мөрөн сум

Барилга, байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол-Солонгосын хамтарсан Ногоон хэрэм төслийн III шатны ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан Сургалт мэдээллийн төвийн барилгыг байнгын ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал

(Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилга хот
байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

П.Мөнхжаргал

Г.Ням-Эрдэнэ

(Аймгийн Байгаль орчны газрын дарга)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын
тасгийн дарга)

Ё.Батсайхан

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
мэргэжилтэн Хөгжлийн бодлого
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн)

Д.Аюушжав

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Эрчим хүчний хяналтын улсын
байцаагч)

Л.Бямбасүрэн

(Аймгийн Онцгой байдлын газрын
Гамшгаас хамгаалах улсын хяналтын
ахлах байцаагч)

Г.Даваадорж

(“Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийн Ерөнхий
инженер)

Ц.Лхачинбат

(Дэлгэрмөрөн сум дундын ойн ангийн
дарга)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Ч.Гэрэлт-Од

(Далан-Од “ХХК-ийн захирал)

6712012040

Ашиглагч байгууллагын төлөөлөл:
Ч.Одсүрэн

(Монгол Солонгосын ногоон хэрэм
төслийн ахлах менежер)

Комиссын нарийн бичгийн дарга:
Д.Сандагдорж

(Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)

2.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Сандагдорж)-д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР